



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ ҮЦЦ ХХК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2023





НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ УЦЦ ХХК

I БҮЛЭГ

АГУУЛГА

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, ЧАНАРЫН БОДЛОГО
САНГУУДЫН ТАНИЛЦУУЛГА, ГҮЙЦЭТГЭЛ

ХОЁР. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ГУРАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН
ЗАСАГЛАЛЫН КОДЕКС
ISO 9001:2015 СТАНДАРТЫГ ХЭРЭГЖИЛТ
ТОГТВОРТОЙ БАЙДАЛ-БОНЗ
САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ БОЛОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР
ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО
ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА
ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ



АЛСЫН ХАРАА

Нийслэлд шинийг санаачлагч,
тогтвортой хөгжлийг дэмжигч,
салбартаа тэргүүлэгч компани
болох.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийслэлийн тогтвортой
хөгжил, хөрөнгө оруулалтын
ашигт байдлыг эрхэмлэнэ.

ЧАНАРЫН БОДЛОГО

Нийслэл болон гадаад, дотоодын мэргэжлийн хөрөнгө оруулагчидтай хамтран байгальд ээлтэй, бүтээн байгуулалтыг дэмжсэн, инновацлаг төсөл хөтөлбөрүүдийг эрсдэлд суурилан хэрэгжүүлэх замаар хөрөнгө оруулалтын ашигт байдлыг нэмэгдүүлж компанийн менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулна.

ҮНЭТ ЗҮЙЛС



Мэргэжлийн
ёс зүй



Мэргэшсэн
хамт олон



Хамтын
ажиллагаа



Бүтээлч
сэтгэлгээ




Мэдээллийн
ил тод
байдал



САНГУУДЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САН

Нийт активын хэмжээ: 2,237,748,710.61₮




Хугацаатай хадгаламжид: 1,982,243,506.55 ₮

Харилцах дансанд: 351,325,181.99 ₮

Энэ онд сангийн нэгж эрхийн үнэ **165,736.00** төгрөгөөр нэмэгдсэн буюу **16.6%**-иар өссөн.

НИЙСЛЭЛИЙН НОГООН САН

Нийт активын хэмжээ: 109,580,480.49 ₮



Хугацаатай хадгаламжид: 109,302,843.85 ₮

Харилцах дансанд: 277,636.64 ₮

Энэ онд сангийн нэгж эрхийн үнэ **84,130.00** төгрөгөөр нэмэгдсэн буюу **8.4%**-иар өссөн.



САНГУУДЫН ГҮЙЦЭТГЭЛ

НИЙСЛЭЛИЙН ГАРААНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САН

Нийт активын хэмжээ: **540,542,028.00₮**




Хугацаатай хадгаламжид: 390,542,028.00 ₮

Рэйт бонд транч 10: 150,000,000.00 ₮

Энэ онд сангийн нэгж эрхийн үнэ **105,553.00** төгрөгөөр нэмэгдсэн буюу **11%**-иар өссөн.

НИЙСЛЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН САН

Нийт активын хэмжээ: **579,931,363.39₮**



Харилцах дансанд: 10,356,801.00 ₮

Хадгаламжийн дансанд: 51,602,234.24 ₮

Рэйт бондонд: 105,573,698.00 ₮

Мираи бондонд: 101,467,123.30₮

Актив бондонд: 152,498,630.14 ₮

Бичил глобус бондод: 158,432,876.71₮

Энэ онд сангийн нэгж эрхийн үнэ **171,713.64** төгрөгөөр нэмэгдсэн буюу **17%**-иар өссөн.



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ УЦЦ ХХК

II БҮЛЭГ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ





ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ТУЗ нь аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын гэсэн 3 хороотойгоор хөрөнгийн зах зээлд мөрдөгдөж буй хууль, дүрэм, журам, зааврын хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллаж байна.

2021 онд батлагдсан ТУЗ-ийн дэргэдэх хороод



Тайлант хугацаанд НИТХ-аас Л.Отгонбаатар-ыг хараат гишүүнээр, Д.Байлхүүг хараат бус гишүүнээр томилж Б.Одсүрэн, М.Аясгалан, Б.Мөнхдөл нарыг чөлөөлсөн байна.

ТУЗ-ийн 2023 оны хурлын мэдээлэл

ТУЗ 1 УДАА ХУРАЛДАЖ 8 АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭСЭН

- ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоол, шийдвэрүүдийн хэрэгжилт 100% -ийн гүйцэтгэлтэй байна.
- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээг Санхүүгийн зохицуулах хороо баталгаажуулалтыг хийн 98,6%-иар үнэлсэн.

100%

Тогтоол
шийдвэрийн
хэрэгжилт


98,6%

Компанийн
засаглалын
кодексийн
үнэлгээ



КОМПАНИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Манай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/04 дүгээр тогтоолоор бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэн 3 газар, 1 алба, 18 орон тоотой батлагдсан бөгөөд 2023 оны эцэст 9 ажилтны бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна.





НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ УЦЦ ХХК

III БҮЛЭГ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН






ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

КОМПАНИЙН 2023 ОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН



ХҮНИЙ НӨӨЦИЙН ЭРГЭЦ



ХҮЙСИЙН ХАРЬЦАА



АЖИЛЛАСАН ЖИЛИЙН БАЙДАЛ

Ажилласан жил	Ажилтны Тоо	Харьцаа
1 жил хүртэл	1	11,3%
1-2 жил	5	55,3%
2-с дээш жил	3	33,3%

ХҮҮХЭД АСРАХ ЧӨЛӨӨТЭЙ 2





ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ

Компани нь 2023 оны байдлаар засаглалын кодексийн 9 зарчмыг хэрэгжүүлж, үнэлгээг ахиулан ажилласан ба СЗХ тус үнэлгээг хянан баталгаажуулсан.

СЗХ-оос гаргасан уг үнэлгээгээр манай компани нь Хөрөнгө оруулалт менежментийн компаниудаас **1-р байрт** шалгарсан байна.

№	Асуулгын бүтэц	2022Q4	2023Q2	2023Q4	62%	98,6%	98,6%
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	91%	91.6%	91.6%			
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	100%	100%	100%			
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	67%	100%	100%			
4	Аудит, хяналтын тогтолцоо	83%	100%	100%			
5	Эрсдэлийн удирдлага	88%	100%	100%			
6	Эрх бүхий албан тушаалтны цалин, нэмэгдэл	100%	100%	100%			
7	Оролцогч талуудын эрх ашиг	88%	100%	100%			
8	Компанийн соёл	83%	100%	100%			
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	100%	100%	100%			
Нэгдсэн дүн		62%	98,6%	98.6%	2022Q4	2023Q2	2023Q4



ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилт

Франц улсын Аfnор группээс 12 сард манай компанийн ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтэд магадлан аудит хийсэн. Аудитын үр дүнд том болон жижиг үл тохирол илрээгүй тул менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээг үргэлжлүүлэн хадгалахаар шийдвэрлэсэн.



“МОНСЕРТФ” ХХК

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, МЕНЕЖМЕНТ
ҮЦК ХХК-Д

2024.01.12 Гэрчилгээний дугаар: MC 11/QMS 177 22 Улаанбаатар хот

МАГАДЛАХ АУДИТЫН ХАРИУ МЭДЭГДЭЛ

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК-ийн үйл ажиллагаанд ISO 9001:2015 Чанарын
менежментийн тогтолцооны хэрэгжилтэд хийсэн “Монсертф” тохирлын үнэлгээний
байгууллагын Магадлах аудитын үр дүнгээр тантай **МЕНЕЖМЕНТИЙН
ТОГТЛОЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ГЭРЧИЛГЭЭГ
ҮРГЭЛЖЛҮҮЛЭН ХАДГАЛАХААР** шийдвэрлэсэн болохыг хариу мэдэгдэж байна.

Аудитын үеэр тогтоосон анхаарах хэсэг, сайжруулах саналуудыг хэрэгжүүлж
ажиллахыг зөвлөж байна.

Хүндэтгэсэн,

Баталгаажуулалтын газрын дарга  Б.Энхтєгс



Certificat
Certificate

N° 2023/103204.1

AFNOR Certification certifies that the management system implemented by:

**ULAANBAATAR INVESTMENT MANAGEMENT SC LLC
OWNED BY THE CAPITAL CITY**

for the following activities:

**ESTABLISHMENT OF INVESTMENT FUNDS FOR ATTRACTING INVESTMENTS,
INVESTING TO PROJECTS AND FINANCIAL INSTRUMENTS;
OPERATION OF FUND ACTIVITIES,
RISK MANAGEMENT.**

has been assessed and found to meet the requirements of:

ISO 9001 : 2015

and is developed on the following locations:

**Sukhbaatar district, 8th khoroo, Prime Minister A.Amar street,
Unen newspaper building, 3rd floor, Ulaanbaatar, 14200, Mongolia**

This certificate is valid from (year/month/day)

2023-01-17

until

2026-01-16





Julien NIZRI
Managing Director of AFNOR Certification



Scan this QR code to
check the validity of the
certificate



CERTIFICATE

Number: MC 11/QMS 177 22

**ULAANBAATAR INVESTMENT
MANAGEMENT SC LLC OWNED
BY THE CAPITAL CITY**

Address: Sukhbaatar district, 8th khoroo, Prime Minister A.Amar street,
Unen newspaper building, 3rd floor, Ulaanbaatar, 14200, Mongolia

has been assessed and found to meet the requirements of:

**QUALITY MANAGEMENT SYSTEMS
ISO 9001:2015**

SCOPE OF CERTIFICATION
Establishment of investment funds,
Investing to projects and financial instruments,
Operation of fund activities and risk management

First issued date: 2022.12.16 Issued date: 2022.12.16
Valid until: 2025.12.15



MONCERTF LLC
Suite 1505, Holmor office, 15th floor,
Altan Street 281, 7th micro district,
Sukhbaatar district, Ulaanbaatar 14182, Mongolia.
Tel: 976-7015522, E-mail: info@moncertf.mn



ТОГТВОРТОЙ БАЙДАЛ-БОНЗ

НҮБ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

ХӨГЖЛИЙН САН



НОГООН САН



ГАРААНЫ САН



Монгол улсын тогтвортой хөгжлийн дараах зорилгуудын хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийг дараах 3 сан дэмжин ажилладаг.



GLOBAL GREEN FINANCE LEADERSHIP PROGRAMME-Д

ХАМРАГДАВ

Уг сургалтаар Монгол улс дахь БОНЗ-ын асуудал хариуцсан ТББ болох “Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо”-ны талаарх ерөнхий мэдээлэл, Монгол улсад одоогоор хэрэгжиж буй БОНЗ-ын бодлого, үзэл баримтлал, таксономигийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийн уялдаа хамаарал, БОНЗ-ын тайлагналын ач холбогдол, олон улсын стандартууд, арга замуудын талаар хүргэж, хэлэлцүүлэгт оролцов.





САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

НХС

1. “ОУ-ын худалдаа ложистикийн төв гаалийн хяналтын бүс” төсөл
2. Нийслэлийн өмчийн ашиглалтыг сайжруулах, менежмент хийх
3. Авто замын сан
4. нийслэл үнэт цаас гаргах
5. Монголын хөрөнгийн бирж хк-ийн хувьцаа
6. Инвексдор ББСБ хк-ийн багцийн хувьцаа
7. Инвексдор бонд

ННС

1. Хуучин орон сууцны дулаалгын төсөл
2. Монголын ногоон санхүүжилтийн корпораци
3. Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл төсөл


НГБДС

1. airee агаар цэвэршүүлэгч
2. “ail” төсөл
3. ббсб-ийн апп хөгжүүлэлтийн төсөл
4. seedshare төсөл
5. yld төсөл
6. metacog төсөл
7. ger camping төсөл
8. gameback төсөл
9. thrift market llc төсөл
10. roco төсөл
11. just төсөл
12. ариун хими төсөл
13. sms-гарааны бизнесийн хөтөлбөрт бэлтгэх
14. 108 цэцэг төсөл
15. тээврийн хэрэгслийн автомат гэрлийн төсөл
16. hand pro төсөл
17. 100 ail.mn төсөл
18. grado төсөл

НЭУС

1. zeely бонд
2. боса бонд
3. ай си рэит бонд
4. актив бонд
5. домог бонд
6. “амар” багц бонд
7. “тайван” багц бонд
8. хан алтай бонд
9. шунхлай бонд
10. нэт бонд
11. bg бонд
12. трэйд бонд
13. нэт бонд
14. мик бонд
15. mfg бонд
16. моннис бонд
16. соно бонд
17. премиум бонд
18. тидиби лизинг бонд
19. форвард гэрээтэй хувьцаа
20. инвексдор нээлттэй бонд
21. инвексдор а бонд

ҮР ДҮН



Нийт 13 хөрөнгө оруулалтаас
303,2 сая төгрөгийн өгөөж
хүртсэн байна.



НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН САНГААС СУДАЛСАН ТӨСЛҮҮД

1. “ОЛОН УЛСЫН ХУДАЛДАА ЛОГИСТИКИЙН ТӨВ” / ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС/ ТӨСӨЛ

- Хамтарсан ажлын хэсэг байгуулагдан 50 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай хөрөнгө оруулах боломжит судалгааг боловсруулан ХОС-аас төсөлд ТЭЗҮ хийх 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын загварчлалыг ОУХЛТөвд танилцуулсан.
- Дэд бүтцэд 7.3 тэрбум төгрөгийг Нийслэлийн 2023 оны төсөвт тусгасан. БНХАУ-ын Beejing Railway Land Bridge, Mon logistics holding LLC-д төслийг танилцуулсан.



Улаанбаатар эдийн засгийн форумын үеэр БНХАУ-ын “**China Railway Construction Corporation**” компанийн Монгол дахь суурин төлөөлөгч Wu Lan, “**Олон улсын худалдаа логистикийн төв**” ХК (ОУХЛТ)-тай “**Хөрөнгө оруулалт татах санамж бичиг**”-ийг байгуулсан. Тус санамж бичиг нь Улаанбаатар хотын баруун хэсэгт байгуулагдах логистикийн нэгдсэн төв байгуулахад хөрөнгө оруулалт татах зорилготой.

Санамж бичгийн хүрээнд 2023 оны 5-р сард манай компани болон БНХАУ-ын “**China Railway Construction Corporation**” компанийн удирдлагууд, Монгол дахь суурин төлөөлөгч Wu Lan нарт Логистикийн нэгдсэн төвийн төсөл, түүний санхүүжилтийн талаар танилцуулга, уулзалтыг зохион байгуулсан.



2.1 “БАГАХАНГАЙН МАХНЫ ҮЙЛДВЭР”-ИЙН ТӨСӨЛ



Барилга болон тоног төхөөрөмжийн одоогийн нөхцөлд үнэлгээ хийлгүүлсэн. Үнэлгээгээр дараах дүгнэлт гарсан. Үүнд:

1. Технологийн дагуу баригдаагүй
2. Хараал хамгаалалт муу учир Тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл нь тоногдсон,
3. Үйлдвэрийн ашиглалт 3-30% муу
4. Дэд бүтэц нь тоногдсон
5. Барилгыг сэргээх засвар үйлчилгээний зардал өндөр
6. 2020 онд Менежментийн гэрээгээр 2 удаа тендер зарласан боловч тендерт шалгарсан ААН байхгүй
7. УБ хотод агуулахын объект байсан нь дуудлага худалдаагаар зарагдсан
8. “Багахангайн мах боловсруулах үйлдвэр” НӨҮГ одоогоор 4 хүний орон тоотой жил бүр 2020-68 сая, 2021- 67 сая, 2022 оны 66 сая төгрөг Нийслэлийн төсөвт тусгуулан ажиллаж явсаар ирсэн.

Багахангайн махны үйлдвэрийн тухай судлан өмчийн харилцааны газартай уулзсан. Өмчийн харилцаанаас эхний мэдээлэл авсан.

Багахангайн махны үйлдвэртэй танилцан үйлдвэрийн тухай танилцуулга гаргасан.

ХХБ-тай уулзалт хийн бичиг баримтыг хүлээн авсан бөгөөд мах боловсруулах үйлдвэрийн зээлийн барьцаанд битүүмжлэх үеийн холбогдох баримт бичгийг хүсэлт илгээж хүлээн авсан.





2.2 “УЛААНБААТАР ХОТЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ” ТӨСӨЛ

Улаанбаатар даатгал ХХК-ийн бизнесийн онцлогт тохирсон, хараат бус үнэлгээний компанийг сонгон шалгаруулж “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн бизнесийн үнэлгээг хийлгэх зорилготойгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Ажлын хэсэг
байгуулсан

Хараат бус үнэлгээний
компани сонгон
шалгаруулсан

Улаанбаатар даатгал
ХХК-ийн бизнесийн
үнэ цэнийг **14,3
тэрбум төгрөгөөр**
үнэлсэн

Даатгалын нөөц санг
удирдах боломжийг
судалсан



УЛААНБААТАР
ХОТЫН
ДААТГАЛ


2023.05.03-ний өдрийн **01** тоот удирдамжаар Улаанбаатар хотын даатгал ХХК-тай хамтарсан 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан.

Ажлын хэсэг нь үнэлгээний компаниудыг судалж 14 компаниас үнийн саналуудыг авсан ба тэдгээрээс 5 компанитай уулзалт хийж удирдамжаар тохирсон аргачлалын дагуу сонгон шалгаруулалт хийж “**Гроут финанс аудит ХХК**” –аар үнэлгээг хийлгэхээр сонгосон.

Шалгарсан компанитай 3 талт уулзалт хийж, Бизнесийн үнэлгээний ажил гүйцэтгэх 3 талт гэрээг байгуулан. Үнэлгээ хийлгэсэн.

Гроут финанс аудит ХХК нь дараах 3 аргаар үнэлгээг хийсэн.

- Орлогын хандлага
- Зах зээлийн хандлага
- Өртгийн хандлага



Даатгалын нөөц сангийн хөрөнгийг удирдах боломжийг судалсан.



3. АВТО ЗАМЫН САН - ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАХ

Ирээдүйн авто замын санд төвлөрөх мөнгөн урсгал, орлогыг санхүүгийн бүтээгдэхүүн (хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас) гаргах замаар хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлж шаардлагатай зам, гүүрний бүтээн байгуулалтыг хийх боломжийг судалсан.

Хуулийн нийцэлд дүгнэлт гаргасан:

Нийслэлийн авто замын сангийн хөрөнгийг үнэт цаасжуулахтай холбоотой Төсвийн тухай хуулийн 6.4.5 хэсэг, Авто замын сангийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчит компанийн тухай зэрэг хуулиуд болон холбогдох эрх зүйн актуудыг судлан дүгнэлт гаргасан.

Тус ажлын хүрээнд хийсэн уулзалтууд:

- **Нийслэлийн авто замын хөгжлийн газар**-тай авто замын сангийн хөрөнгөөр хийх ажлын төлөвлөгөөтэй танилцах уулзалт
- **Нийслэлийн төрийн сан**-тай Нийслэлийн авто замын сангийн сүүлийн 5 жилийн санхүү байдлын орлого зардлын тайлантай танилцах уулзалт
- **Хууль, өмгөөлөгч Мөнхдаваа, Баасандорж** нартай Авто замын сангийн хөрөнгийг үнэт цаасжуулах ажилд хууль зүйн дүгнэлт гаруулж, хамтран ажиллах талаарх 2 удаагийн уулзалт
- **Өмгөөллийн “Барристер Кастос” ХХК**-тай мөн Авто замын сангийн хөрөнгийг үнэт цаасжуулах ажилд хууль зүйн дүгнэлт гаруулж, хамтран ажиллах талаарх уулзалтуудыг тус тус хийсэн.

Шийдэл:

- Төсвийн захирагч нь төсвийн бүрэлдэхүүн болох төсвийн сангийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргаж болохгүй гэсэн заалтыг **тодорхой тохиолдолд барьцаалах эсхүл баталгаа гаргаж болох зохицуулалтыг нэмэлтээр оруулах**
- Нийслэлийн авто замын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, төлөвлөх, захиран зарцуулах тусдаа бие даасан журам мөн Нийслэлийн авто замын хөрөнгийг үнэт цаасжуулах журам зэргийг шинээр батлуулах замаар хууль эрх зүйн орчныг сайжруулж үнэт цаас гаргах боломж бүрдэнэ.



4. “НИЙСЛЭЛИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАХ” ТӨСӨЛ

Нийслэлийн Засаг даргын 2023.05.04-ний өдрийн А/446 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж Нийслэлийн бондын тухай дэлгэрэнгүй судалгаа мэдээллүүдийг боловсруулсан.

2023.05.04

Эрх зүйн орчныг судалж “Нийслэл үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээллэх журам”-ыг Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулсан. Иймд Нийслэл хуульд заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгтээр дотоодын зах зээлд үнэт цаас гаргах суурь нөхцөл бүрдсэн.

2023.05.24

“Нийслэлийн үнэт цаасанд андеррайтерийн зөвлөх үйлчилгээний ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хорооны даргаар ажиллан тендерийн үйл ажиллагааг зохион байгуулсан.

2023.05.31

2023.06.11

НИТХ-д танилцуулах материалыг боловсруулж, НИТХ-ийн 55 дугаар тогтоолоор Нийслэлийн үнэт цаасыг дотоод зах зээлд гаргахыг дэмжив.

2023.07.06

Нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргаж, арилжаалах саналыг холбогдох хууль, журмын дагуу хянан үзэж дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх хүсэлтийг Сангийн яаманд гаргав.

2023.07.17

Сангийн яамнаас Нийслэлийн үнэт цаасыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үе шаттайгаар арилжаалахад татгалзах зүйлгүй гэх дүгнэлтийг ирүүлэв.



НЗДТГ-н даргын **A/170** тушаалаар ажлын хэсэг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар гүйцэтгэх захирал Л.Тэмүүжин, нарийн бичгийн даргаар ерөнхий менежер Ө.Мөнхдаваа нар томилогдож “БиДиСек ҮЦК” ХК –тай гэрээний нөхцөлийг харилцан тохиролцов.

“БиДиСек ҮЦК” ХК нь техникийн саналаар хамгийн өндөр оноо авч **Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын 3/1226** тоот албан бичгээр андеррайтерийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх **гэрээ байгуулах эрхийг** олгосон.

2023.08.02

2023.08.03

2023.08.18

2023.10.01

“**БиДиСек ҮЦК**”-тай Андеррайтерийн зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулж, “Улаанбаатар бонд”-ыг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэх, нийтэд санал болгох ажиллагаанд шаардагдах баримт бичгийн жагсаалт /Checklist/-ыг боловсруулан БиДиСек ҮЦК”-д хүлээлгэн өгсөн.

“**Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам**”-ын түргэн борлогдох хөрөнгөнд НҮЦ-ыг хамруулж, НҮЦ-ыг Төв банкнаас санхүүжилт олгоход **барьцаалах хөрөнгийн жагсаалтад** бүртгүүлж, барьцаа хөрөнгийн эрсдэлийн хямдруулалтын хэмжээг **Засгийн газрын үнэт цаастай адилтгах** мөн активын эрсдэлийн жигнэсэн дундаж хувийг 80 хувь болгох зэрэг асуудлуудыг Монгол банканд хүсэлт гарган шийдвэрлүүлсэн.



2023.08.23

Санхүүгийн зохицуулах хороо болон **Монголын хөрөнгийн биржид** бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүргүүлсэн.



2023.09.01

Монголын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирлын А/160 тоот тушаалаар Нийслэлийн үнэт цаасыг бүртгэсэн. **Санхүүгийн зохицуулах хорооны №427** тоот тогтоолоор Нийслэлийн үнэт цаасыг дотоодын зах зээлд, олон нийтэд санал болгох зөвшөөрлийг олгосон.



НИЙСЛЭЛИЙН НОГООН САНГААС СУДАЛСАН ТӨСЛҮҮД



Mitigation Action
Facility

1. ХУУЧИН ОРОН СУУЦНЫ ДУЛААЛГЫН ТӨСӨЛ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Угсармал орон сууцанд дулаан техникийн шинэчлэл хийх замаар барилгын дулаан алдагдлыг бууруулж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах юм.

ТӨСЛИЙН ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГА

Төсөл хэрэгжүүлэгч нь **Mitigation Action Facility** бөгөөд хамтрагч байгууллагуудаар Монгол улсын Барилга хот байгуулалтын яам, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Алба (ЗАА), Эрчим хүчний зохицуулах хороо (ЭХЗХ), Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ) ажиллаж байна.



Төслийн хүрээнд дараах арга хэмжээний тусламжтайгаар барилгын эрчим хүчний хэмнэлтийг дэмжинэ:

- Угсармал орон сууцны барилгын засвар шинэчлэлийн ажлын санхүүжилтийг урт хугацаанд хангах зорилгоор эрчим хүчний хэмнэлтийн сан байгуулах.
- Улаанбаатар хотын нийт угсармал орон сууцны барилгуудын 30%-ийг засварлаж шинэчлэх.
- Эрчим хүчний хэмнэлтэд хөрөнгө оруулалт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх.
- Эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хамтран ажиллах байгууллагуудын институтийн болон техникийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

ХИЙГДСЭН АЖЛУУД

Манай компани нь төсөл хэрэгжүүлэгчтэй уулзан, төслийн мэдээллийг хүлээн авч, судалгаа шинжилгээ хийсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч талаас нийцлийн үнэлгээг хийхээр Нийслэлийн ногоон сан болон ХОМК-ийн баримт бичгүүдийг авсан.



2. МОНГОЛЫН НОГООН САНХҮҮЖИЛТИЙН КОРПОРАЦИ

“Нийслэлийн хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөө”-ний 2.1.9-д тусгагдсан **“Монголын ногоон санхүүгийн корпорацийн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх”** ажлын хүрээнд Монголын Ногоон санхүүжилтийн корпоратай хамтран Гэр хорооллын амины орон сууцны төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Нийслэлийн төсөвт уг төслийн үлдэгдэл санхүүжилт болох **5 сая долларыг** суулгахаар холбогдох журмын дагуу саналыг боловсруулан өмнөх онд өгсөн.



2023.02.28-нд Хүлэмжийн хийн бууралтыг багасгасан гэр хорооллын амины орон сууцны баригдсан төсөлтэй танилцаж, барилгын бүтээн байгуулалт, дэд бүтэц, хөрөнгө оруулалт болон бусад асуудлаар уулзалт хийсэн. Нийслэлийн зүгээс хүлээсэн **17.5 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалтыг 2023 оны 9 сарын 28 өдөр **Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд** оруулж батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас манай компани дээр **төлөөлөх итгэмжлэл авах**, үлдсэн хөрөнгө оруулалтыг шийдэх, ногоон санхүүжилтийн корпорацийн бичиг баримтад хуулийн нийцэл хийх, мөн тус төслийг **Нийслэлийн Ногоон сан Хувийн ХОС ТЗК ХХК-иар** дамжуулан хэрэгжүүлэхэд чиглэн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийж ажиллав.



3. УЛААНБААТАР ХОТЫН ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦ БА ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР БҮХИЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ



GREEN
CLIMATE
FUND



ASIAN DEVELOPMENT BANK



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

Гэр хорооллын дэд төвүүдэд нүүрс хүчлийн хийн ялгарал багатай “Орлогод нийцсэн ногоон орон сууцны эко хороолол байгуулах” зорилтыг хэрэгжүүлэхийн хүрээнд санхүүжилтийг **Нийслэлийн ногоон сангаар дамжуулан** удирдах боломжийг судлан үзэж, эдийн засгийн тооцоолол болон холбогдох саналыг боловсруулсан.

Мөн **Нийслэлийн орон сууцны бодлогын газар, Нийслэлийн орон сууцны корпорац, Улаанбаатар хотын ногоон орон сууц төслийн баг, Шинэ дэд төв** зэрэг газруудтай хамтран “Гэр хорооллыг хөгжүүлэх” үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан НЗД болон холбогдох газруудад танилцуулсан.



НЗДТГ, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дэргэдэх төсөл хэрэгжүүлэх нэгж нь уг төслийн санхүүжилтийг татах Хөрөнгө оруулалтын санг манай компаниар удирдуулан хэрэгжүүлэх тухай саналыг НЗДТГ-тай хэлэлцэж, **2023.07.05-ний өдөр** Сангийн яаманд **01/4218 тоот** албан хүсэлт өгсөн.

Тус хүсэлтийн дагуу сангийн яамтай урьдчилсан байдлаар төслийн санхүүжилтийг манай компаниар хэрэгжүүлэхээр тохиролцсон бөгөөд сангийн яамнаас төслийн санхүүжүүлэгч болох Азийн хөгжлийн банк руу уг мэдэгдлийг хүргүүлсэн.





3. УЛААНБААТАР ХОТЫН ОРЛОГОД НИЙЦСЭН ОРОН СУУЦ БА ДАСАН ЗОХИЦОХ ЧАДВАР БҮХИЙ ХОТЫН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ



GREEN
CLIMATE
FUND



ASIAN DEVELOPMENT BANK



САНГИЙН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

2023 оны 11-р сард АХБ-аас Манай компани болон итгэмжлэн удирдаж буй сангуудад үнэлгээ хийх зорилгоор **“Financial Management Assessment Questionnaire”** буюу үнэлгээний асуулгыг ирүүлсэн.



Уг асуулгын хүрээнд ХОМК болон сангуудын мэдээллийг бөглөж, шаардлагатай санхүүгийн тайлан, журам, баримт бичгүүдийг бүрдүүлж илгээсэн ба одоогоор Азийн хөгжлийн банк хянан нийцүүлэлтийг хийж гүйцэтгэж байна.





ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД

“ТУУЛ ГОЛЫН ЭРГИЙН ТОХИЖИЛТ”-ИЙН ТӨСӨЛ

2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр “Туул голын эргийн тохижилт” төслийн хүрээнд

- Төсөл хамтран хэрэгжүүлэх гэрээ
- Хувьцаа эзэмшигчдийн гэрээг байгуулсан.
- Тус ажлын хүрээнд 2020-2021 онд ажлын хэсэг удаа дараа хуралдан төсөл хэрэгжүүлэх гэрээ, компани үүсгэн байгуулах тогтоол гаран хамтарсан компани үүсгэн байгуулагдсан.




2022 онд Усны газар, Экологийн цагдаагийн алба, УСУГазар болон БХБЯам, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын захиалгаар үерийн хамгаалалтын далангийн ажлын зураг зураг тендерт шалгарсан Хайдро прожект ХХК болон хамтарсан компанийн удирдлагууд 2023.05.10-ны өдөр уулзалт хийсэн.

Тус үерийн далан нь төсөл хэрэгжих талбайтай давхцал үүсгэсэн тул хөрөнгө оруулагч тал далангийн ажлын гүйцэтгэлтэй төслийн талбайг давхцуулахгүй байдлаар зураг төслийн төлөвлөгөөг шинээр хийхээр харилцан тохиролцож, улмаар зураг төсөл, төслийн танилцуулга шинэчлэн батлагдсанаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал болон НИТХ-д уламжлан, хэлэлцүүлэх ажлууд хийгдэж байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛСАН САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД

Сая.төг





ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд **14** үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр батлуулсан бөгөөд төлөвлөгөөний гүйцэтгэл **90%**-тай байна.

ЭРСДЭЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Эрсдэлийн зөвлөл нь дараах **3** агуулгын хүрээнд **10** удаа хуралдаж **21** асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн байна.



КОМПЛАЕНСЫН ХЯНАЛТ

Хууль, дүрэм журмын нийцэл, хэрэгжилтийг хангуулах хяналтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

- ✓ “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-ыг шинэчлэн боловсруулсан
- ✓ СЗХ-ны “КОМПЛАЕНС-ын ажилтныг мэргэшүүлэх” сургалтад 5 ажилтныг хамруулж чадавхжуулсан
- ✓ “КОМПЛАЕНСын хөтөлбөр”-ийг батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласан.




ДОТООД ХЯНАЛТ

Дотоод хяналт нь 5 зорилтын хүрээнд 24 ажил төлөвлөж, биелэлтийг бүрэн хангаж ажилласан.

Нийт хяналт шалгалтын хүрээнд холбогдох ажилтнуудад 45 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн биелэлт нийт **90%**-тай байна.


Зөвлөмжийн биелэлт





ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



LVS CAPITAL LIMITED
恒廣通資本有限公司

Гүйцэтгэх захирал 2023.06.27-2023.07.01 ны өдрүүдэд БНХАУ-ын Бээжин хотод Хөрөнгө оруулалт татах уулзалтад оролцон бөгөөд тус улсын “LVS capital partner limited” LLC-тэй хөрөнгө оруулалт татах, **санамж бичиг** байгуулсан.

ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Эдийн засгийг эрчимжүүлж, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагаас хөрөнгө оруулалт татах зорилгоор Улаанбаатар хотын эдийн засгийн форумыг зохион байгуулах ажлын эсгийн нарийн бичгээр ажилсан.



Ulaanbaatar International
Investment & Partnership
Forum 2023

NEW RECOVERY - ULAANBAATAR

Мөн итгэмжлэн удирддаг Хөрөнгө оруулалтын сангуудын танилцуулгыг хийж, Нийслэлийн гарааны бизнесийг дэмжих сангаас хөрөнгө оруулалт хийх боломжит start-up компаниудын бизнесийн төслүүдтэй танилцах, судлах зэргээр оролцсон.



НИЙСЛЭЛИЙН АЖЛЫН ХЭСЭГ

A/172	Эдийн засгийг эрчимжүүлж, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллагаас хөрөнгө оруулалт татах зорилгоор Улаанбаатар хотын эдийн засгийн форумыг зохион байгуулах
A/446	Улаанбаатар хот үнэт цаас гаргах эрх зүйн орчныг судалж, бэлтгэл ажлыг хангах, санал дүгнэлт боловсруулах
A/170	“Нийслэлийн үнэт цаасанд андеррайтерийн зөвлөх үйлчилгээний ажил”-ын худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад өндөр оноо авсан зөвлөхтэй хэлэлцээр хийж, гэрээний төсөл боловсруулан танилцуулах
A/44	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх “ Нийслэлийн үнэт цаасанд андеррайтерийн зөвлөх үйлчилгээний ажил ”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны ажлын хэсэгт
	2024 оны Нийслэлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах дэд ажлын хэсэг
A/1482	Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн журам боловсруулах ажлын хэсэг



ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

Нийслэл дэх Төрийн аудитын газрын шийдвэрээр сонгогдсон **Си Эс Ай Аудит ХХК** нь гэрээний дагуу 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж ажилласан. Уг аудитаар өөрчлөлтгүй гэсэн дүгнэлт гарсан.



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
МЕНЕЖМЕНТ УЦЦ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Л.ТЭМҮҮЖИН ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент УЦЦ ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, олголын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент УЦЦ ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандар, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заварын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан ханиалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт эгэх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент УЦЦ ХХК 4 сантай үйл ажиллагааг өргөжүүлэн явагдаж Нийслэлийн ногоон сангаар дамжуулан Азийн хөгжлийн Банк болон Уур амьсгалын ногоон сангаас хэрэгжүүлэх ногоон орон сууцны төслийг хэрэгжүүлж байгууллагаар шалгарч Азийн хөгжлийн банкны урьдчилсан нийцлийн үнэлгээ хийгдэж шалгуурыг хангасан байна.

Аудитын гол асуудал

Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент УЦЦ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн дүрмээр улиралд 1 удаа хуралдаана гэж заасан боловч жилд 1 удаа хуралдсан байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/03 дугаар тогтоолоор нийт орлогыг 1,473,025.0 мянган төгрөг, нийт зардлыг 1,397,304.5 мянган төгрөг, 75,720.5 мянган төгрөг байхаар эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
МЕНЕЖМЕНТ ҮЦЦ ХХК



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ
УЛААНБААТАР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ,
МЕНЕЖМЕНТ ҮЦЦ ХХК

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД
БАЯРЛАЛАА

